



№02 (141)

2023 оны 02-р сар

"ДЦС-4" ТӨХК-ийн сар тутмын сонин

ЭНЭ ДУГААРТ:

40 ЖИЛИЙН ОЙН
ЛОГО ШАЛГАРУУЛАХ
УРАЛДААНД ИРҮҮЛСЭН
БҮТЭЭЛҮҮДЭЭС

2-р нүүрт

**2023 ОНЫ 1-Р
САРЫН ТЭЗҮ**

3-р нүүрт

**2023 ОНЫ 1-Р САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

4-р нүүрт

**ХАЙЛТЫН СИСТЕМҮҮД
ХИЙМЭЛ ОЮУН УХААНААР
ХҮЧ НЭМЛЭЭ**

5-р нүүрт

**СПОРТЫН
МЭДЭЭ**

6-р нүүрт

**ЯСНЫ СИЙРЭГЖИЛТИЙН
ХЭМЖИЛТИЙН ДҮН**

УУШГИ ТООСЖИХ ӨВЧИН

7,8-р нүүрт



Сонины талаарх санал хүсэлтээ 2125, 2602 дугаарын утас, sxa@tpp4.mn эсвэл СХА-нд файлаар болон бичгээр өгч болно.

www.tpp4.mn/erchim

**“ДЦС-4” ТӨХК-ИЙН ТҮҮХТ 40 ЖИЛИЙН ОЙН
ЛОГО ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ ДҮН**



“ДЦС-4” ТӨХК-ийн түүхт 40 жилийн ой 2023 онд тохиож байгаатай холбогдуулан ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын мэдээлэл сурталчилгаа, бүтээн байгуулалт, бэлэг дурсгалыг ойн бэлгэдлээр чимэглэж дурсгал болгон мөнхжүүлэх зорилгоор компанийн нийт ажиллагсдын дунд логоны уралдааныг 2022

оны 12-р сарын 22-ноос 2023 оны 01-р сарын 25-ны хооронд амжилттай зохион байгууллаа. Уралдаанд нийт 12 ажилтны 33 бүтээл ирснийг ГЗ-ын тушаалаар томилогдсон комисс хэлэлцэж, санал хуралтаар тэргүүн байр болон дэд байруудыг шалгарууллаа.

Уралдаанд бүтээлээ ирүүлсэн ажилтнууд

№	Нэгж	Албан тушаал	Нэр	Загварын тоо
1	НАХ	Барилга байгууламжийн засвар хяналтын инженер	Б.Батсүрэн	2
2	ДХХАЦ	Хамгаалалт, автоматикийн засварчин	О.Нямцогт	2
3	НАХ	Байгууламжийн чанар, стандартын техникч	Ө.Шийрэвнямбуу	1
4	ЗЦ	Туслах тоноглолын машинч	З.Бат-Өлзий	2
5	ТДЦ	Ашиглалтын мастер	Э.Бумжаргал	2
6	ТЦ	Бойлерын машинч	С.Наранбаатар	1
7	СХА	МТ хариуцсан ахлах инженер	Н.Галцог	4
8	ДХХАЦ	Хамгаалалт, автоматикийн засварчин	Г.Бямбажав	11
9	ЗХНА	Чанар, бүтээмжийн мэргэжилтэн	Д.Ширчин	2
10	ЦЦ	Ээлжийн монтер	Б.Балжинням	1
11	ҮА	Цахилгаан тоноглолын ашиглалтын инженер	П.Өнөрбаяр	4
12	ЭЗЦГ	Хоолзүйч	Г.Пунсалмаа	1



Тэргүүн байр



Дэд байр

Хамгаалалт, автоматикийн засварчин О.Нямцогтын №2 хувилбарын логог тус тус шалгаруулж, тэргүүн байр эзэлсэн логог зохиогчтой зөвшилцөн сайжруулж, компанийн 40 жилийн ойн лого, билэг тэмдэгээр баталлаа. Авьяас билэг, ур чадвараа дайчлан, сэтгэл гарган оролцсон нийт ажилтнууддаа цаашдын ажилд нь амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Уралдааныг зохион байгуулах комиссын шийдвэрээр тэргүүн байрыг СХА-ны МТ хариуцсан ахлах инженер Н.Галцогийн №3 хувилбарын лого, дэд байрыг ДХХАЦ-ийн

40 ЖИЛИЙН ОЙН ЛОГО ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНД ИРҮҮЛСЭН БҮТЭЭЛҮҮДЭЭС



2022–2023 ОНЫ ӨВЛИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ОРГИЛ АЧААЛАЛ 1474 МВТ ХҮРЭЭД БАЙНА

Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн салбарын үйлдвэр, компаниудын удирдлагуудын ээлжит өргөтгөсөн шуурхай хурал /2023.01.31/-ыг зарлан хуралдууллаа. Хуралд төрийн болон орон нутгийн өмчит 47 байгууллага оролцож, 2022–2023 оны өвөлжилт болон тулгамдаж буй асуудлуудын талаар хэлэлцэв.



Хурлын эхэнд “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК мэдээлэл хийсэн. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 4.7%–аар өссөн бол, 2022–2023 оны өвлийн горимын төлөвлөлт 2.45%–аар нэмэгдсэн нь гадна агаарын температур олон жилийн дунджаас илүү өндөр байгаатай холбон тайлбарлалаа. Мөн 2023.01.24–ний өдөр эрчим хүчний систем 1474 МВт хүрч ажилласан нь энэ өвлийн хамгийн өндөр үзүүлэлт болоод байна.

Сайд Б.Чойжилсүрэн хурлын үеэр үйлдвэр, компаниудад үүсээд буй өр, авлагыг бууруулахад онцгой анхаарч ажиллах, аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалтыг хуваарийн дагуу тогтмол хийх, 2023 оны мөнгөн урсгалыг сар бүр гаргаж танилцуулах, баяр ёслолын үеэр хариуцлагатай ажиллах зэрэг үүрэг даалгаврыг өгсөн. Мөн дулааны болон дулааны цахилгаан станцууд, эрчим хүчний нүүрс олборлогч уурхайнууд богино хугацаанд өсөн нэмэгдэх хэрэглээний тооцооллыг гаргаж танилцуулахаар боллоо.

Энэ өвлийн цаг агаар олон жилийн дундажтай харьцуулахад хүйтэн байгаа ч салбарын хамт олон зүтгэлтэй ажиллаж, сайн давж байгааг онцолсон юм.

2023 ОНЫ 1-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төлөвлөгөөний биелэлт

Горимын даалгавараас 4979,992 мян.кВтц цахилгаан эрчим хүч илүү үйлдвэрлэж, 1749,478 мян.кВтц-аар зөрчиж, төлөвлөгөөг 3230,514 мян.кВтц-аар давуулан биелүүлсэн. Цахилгаан эрчим хүчний доод ачаалал 585 МВт, дээд ачаалал 732 МВт байлаа.

Диспетчерийн графикийн төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт,%
ЦЭХ-ний түгээлт	сая.кВтц	451.8	455.0	+3.2	100.7%
ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	687.6	687.6	-	100.0%

Тайлант хугацаанд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө: ЦЭХ - **100,7%**, ДЭХ - **100,0%** биеллээ.

ДҮТ-ийн диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө болон биелэлт

Нэмэх шийдвэр		Хасах шийдвэр		Диспетчерийн графикийн зөрчил		Ачаалал		Диспетчерийн төлөвлөгөөний биелэлт	Диспетчерийн графикийн нэмэх зөрчил
Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Дээд	Доод	мян.кВтц	мян.кВтц
51	4979.992	42	2381.424	1	1749.478	732	585	3230.514	-

СПОТ зах зээлийн талаар

СПОТ арилжааны зах зээлд **399,548** мян.кВтц буюу **11804,219** мян.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж, **202,478** мян.кВтц буюу **9050,173** мян.төгрөгний ЦЭХ худалдан авч, авлага өглөгийн зөрүүгээр **2754,046** сая. төгрөгний ашигтай ажиллалаа.

Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний биелэлт

Цахилгаан эрчим хүчний үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөг **13,5** сая.кВтц-аар давуулан **103,0%**-н биелэлттэй ажиллалаа. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **13,4** сая. кВтц ЦЭХ илүү түгээж **3,0 %** -н өсөлттэй байна.

Дулааны эрчим хүчний үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө **19,8** мян.Гкал-аар давж **103,0%**-н биелэлттэй байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **48,4** мян.Гкал ДЭХ илүү түгээж **7,6%** -н өсөлттэй байлаа.

Өнгөрсөн оны нэгдүгээр сартай харьцуулахад гадна агаар хэм **3°C**-ээр хүйтэрсэн байна. Сүлжээний усны зарцуулалт **435 т/ц**-аар, халуун **1,63°C** өссөн тул дулаан түгээлт нэмэгдсэн байна. Тайлант сард туслах бойлер болон **210 МВт**-н дулааны дэд станц тасралтгүй ажилласан.

Үндсэн тоноглолын ажиллагаа

Горим ажиллагаанд 8 зуух, 7 турбин бүгд оролцсон. Сарын дунджаар 7,95 зуух, 7,0 турбинтэй ажиллаж зуух, турбин бэлтгэлгүй байлаа.

Нүүрсний зарцуулалт /УСТ тарифт тусгагдсан нүүрснээс/

Уурхай	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт
Багануур	мян.тн	210.00	209.498	-0.502	99.8%
Шивээ-Овоо	мян.тн	205.00	211.930	+6.930	103.4%
Бүгд	мян.тн	415.00	421.428	+6.428	101.5%

Мазутын зарцуулалт

Энэ сард 120 тн мазут түлэх төлөвлөгөөтэйгээс 28 тн-г түлж, 92 тн мазутын хэмнэлт гаргалаа.

Тайлант хугацаанд 1 удаагийн халуун, 1 удаагийн хүйтэн галлагаа хийсэн.

Жишмэл түлшний зарцуулалт

Цахилгаан эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл

түлшийг - 12.355 гр/кВтц-аар, дулааны эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшийг - 0.313 кг/Гкал-аар хэмнэж гүйцэтгэлд ноогдох төлөвлөлтөөс 5837 тн жишмэл түлш буюу 12322 тонн бодит түлш /илчлэг 3316 ккал/кг/ хэмнэсэн.

Горим параметрийн даалгаврын биелэлт

ТБНС-ний 2023 оны цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлт, түгээлтийн батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ДХЦЭХ-ний зарцуулалт 0,24 %-иар буюу 1248,912 мян.кВтц-аар хэтэрсэн.

Нэгж бүтээгдэхүүнд оногдох ЦЭХ-г гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөө, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй тус, тус харьцуулбал:

№	Үзүүлэлт	Нэгж	1-р сар	
			Төлөв	Гүйц
1	1 тн нүүрс нунтаглахад зарцуулах цахилгаан	кВтц/ тн.нүүрс	28.07	28.67
2	1 тн уур боловсруулахад зарцуулах үлээлт соролтын цах.	кВтц/ тн.уур	4.24	4.33
3	1 тн тэжээлийн ус шахахад зарцуулагдах цахилгаан	кВтц/ тн.тэж ус	7.53	7.69
4	Эргэлтийн усны насос зарцуулагдах цахилгаан	%	0.91	0.93
5	Дулаанжуулалтын насос зарцуулагдах цахилгаан	кВтц/Гкал	0.63	0.64

Уур усны алдагдал

Станцын дотоод циклийг нөхөх химийн цэвэрлэсэн усны зарцуулалтыг 0,33%-аар буюу 8291тн-оор хэмнэсэн. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны зарцуулалт 15605 тонн-оор нэмэгдсэн. Дотоод циклийг нөхөх усны зарцуулалт цагт дундажаар 164 т/ц байсан. Осмосын халаагч уурын зарцуулалт 5109 тн байлаа.

Дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр:

- Турбинд - 76865 м³ ус өгсөн.
- Зууханд - 32 м³

БКБ-аас цэвэрлэгдсэн конденсатын зарцуулалт - 21152 м³ байлаа.



2023 ОНЫ 1-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2023 оны 1-р сард станцын хэмжээний аваари, 1 болон 2-р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 2 бүртгэгдсэнээс зуух 2 удаа зогссон. Хүний буруутай үндсэн тоноглолын зогсолт гараагүй.

№	Зогсолтын шалтгаан	Хамгаалалтаар		Захиалгаар		Бэлтгэлд		Саатал, гэмтлээр		Нийт зогсолт	
		2022 оны 1-р сар	2023 оны 1-р сар	2022 оны 1-р сар	2023 оны 1-р сар	2022 оны 1-р сар	2023 оны 1-р сар	2022 оны 1-р сар	2023 оны 1-р сар	2022 оны 1-р сар	2023 оны 1-р сар
1	Зуух	1	-	1	-	-	-	2	2	4	2
2	Турбин	1	-	-	-	-	-	3	-	4	-
	Дүн	2	-	1	-	-	-	5	-	8	2

- Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт: ЭЗЦГ-1 /437.2 мян₮/ бүгд-1 /437.2 мян₮/

- Тоног төхөөрөмж, сэлбэг материал ашиглалтаас хасах акт: ТЦ-1, ЗЦ-1 бүгд-2

Нийт 3 ширхэг /437.2 мян₮/ акт тогтоогдсон.


Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн байдалд хийсэн хэмжилт. (Нэг удаагийн)

№	Цех нэгжүүд	Дуу шуугиан (85 дБ)		Ажлын байрны халуун (12-30 °C)		Ажлын байрны чийглэг (30-60 %)		Ажлын байрны тоосролт (10 мг/м³)		Тайлбар
		2022 оны 1-р сар	2023 оны 1-р сар	2022 оны 1-р сар	2023 оны 1-р сар	2022 оны 1-р сар	2023 оны 1-р сар	2022 оны 1-р сар	2023 оны 1-р сар	
1	ТДЦ	70.3	66.6	8.9	9.1	51.5	50.1	17.0	15.5	-1.5 пунктээр буурсан.
2	ЗЦ	82.2	82.8	25.7	23.6	21.5	22.7	10.4	11.6	+1.2 пунктээр өссөн.
3	ТЦ	71.3	78.9	19.6	24.3	30.2	24.0	13.7	13.55	Станцын дундаж тоосролт
4	Хими	71.4	78.1	17.3	21.9	31.7	27.4			
5	Механик	79.6	77.1	17.2	16.4	16.1	21.5			

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

1. Хяналтын чиглэлээр			
№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	Нарядын мөрдөлтөнд хяналт хийсэн байдал	100%	18 нарыдад сонголтоор хяналт хийсэн.
2	Ажлын байранд хяналт хийсэн байдал	100%	Цехүүдээр эргэлт хийсэн.
2. Сургалт, зааварчилгаа			
1	Урьдчилсан зааварчилгаа өгөгдсөн байдал	100%	98 хүнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
2	Шинээр ажилд орж байгаа иргэний сургалтын талаар	100%	29 иргэнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
3	Ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалтын талаар	100%	1 ажилтнаас шалгалт авсан.
4	Бусад сургалтын талаар	100%	Нийт ажилтны ХАБ-ын сургалт зохион байгуулж 914 хүн хамрагдсан. Зэрэг ахиж буй 5 ажилтнаас шалгалт авсан.
3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн талаар			
1	МХЕГ ХАБҮЛ лабораторитой байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих.	100%	2023 онд ХАБҮЛ лабораторитой гэрээ хийх хүсэлт хүргэж өгсөн. 2 дугаар сараас гэрээ хийнэ.
2	Хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх.	100%	Үндсэн 6 цехэд хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийгдсэн.
3	Ариутгал халдваргүйтгэлийн талаар	100%	Тогтмол хяналт тавьж ажилласан.
4	Шавьж устгал, ундны усны шүүлтүүр солих ажилд хяналт хийгдсэн байдал.	100%	Тогтмол хяналт тавьж ажилласан.
5	Тоосролтын хэмжилтэнд хяналт хийсэн байдал	100%	Нийт 4 удаа хэмжилт хийгдсэн /Хэмжилт хийхэд хяналт тавьж ажилласан/.
4. Бусад ажлын талаар			

- МЦ, ТЦ, YA, СБХ –үүдэд хөтөлбөрийн дагуу ISO 45001:2018 стандартаар дотоод аудит хийсэн.
- Нийт ажилтны сургалтыг YЭХ-той хамтарч зохион байгуулж хийсэн. 914 ажилтан хамрагдсан.
- “Ногоон титэм” ХХК -тай хамтран тоосжилтийн хэмжилт хийсэн /ТДЦ-ийн тоосролтын хэмжих багаж, ХЦ-ийн АЭРА багажаар давхар хэмжсэн/.



2023 оны 2-р сарын 8-нд Microsoft өөрийн веб хөтөч Edge болон хайлтын систем Bing-ийг сүүлийн үед шуугиан тарьж буй AI чатбот ChatGPT-ийн илүү хүчирхэг хувилбартай нэгтгэснээ зарлалаа.

Bing хайлтын системтэй холбосон ухаалаг чатбот нь вэб хуудсуудыг шүүж, олон эх сурвалжаас баталгаажуулахаас гадна и-мэйл бичиж, орчуулга хийх чадвартай аж.

ChatGPT бол хүний хэл ярианд суурилсан хиймэл оюунтай чатбот бөгөөд хүмүүсийн асуусан асуултад хамгийн үнэн зөв хариулт өгөх чадвартай систем юм.

ChatGPT системийг ашигласнаар Bing нь хайлтын үр дүнг уламжлалт вэб холбоос хэлбэрээр биш, илүү амьд, тодорхой, ухаалаг хэлбэрээр харуулдаг болох юм. Тухайлбал хайлтын үр дүнг харуулахдаа ойролцоо агуулгатай вэб сайтуудын холбоосыг жагсаахаа больж, харин тэдгээрийг нэгтгэн дүгнээд эцсийн ганц хариултыг өгдөг болно гэсэн үг.



Танилцуулгын үеэрээ Bing-ээс жор, аялалын зөвлөгөө, Ikea-с тавилга худалдаж авах зэрэг хэд хэдэн хайлтыг жишээ болгож үзүүлэв. Bing-ээс Мексико хотод хийх 5 өдрийн аялалын маршрут гаргахыг хүссэн бөгөөд энэ асуултад чатбот дэлгэрэнгүй хариулж нэмэлт мэдээлэл авч болох линкийг аялалын маршрутын бүдүүвч зургийн хамт харуулсан байна.

Хайлтын үр дүнг илүү нарийн болгохын тулд шинэ систем нь хэрэглэгчтэй харилцан ярилцдаг (interactive) болж байгаа юм. Тухайлбал ямар нэг сэдвээр мэдээлэл хайхад хүсэлтийг нь илүү дэлгэрэнгүй ойлгохын тулд хайлтын систем талаас нэмэлт тодруулга асуултыг хэрэглэгчид буцааж тавина гэсэн үг.

Microsoft-ийн шинэ Bing хайлтын систем нь одоогоор зөвхөн суурин компьютерүүд дээр ашиглах боломжтой байгаа бөгөөд ирэх долоо хоногоос гар утас дээр ашиглах боломжтой болох юм байна. Учир нь энэ хугацаанд хэрэглэгчдийн өгсөн санал шүүмжлэлийн тусламжтайгаар сайжруулалт хийнэ гэж төлөвлөсөн бөгөөд одоогоор энэ технологийг буруугаар ашиглахаас зайлсхийх арга замуудыг боловсруулж байгаа аж.

Үүнтэй зэрэгцэн Google компани өөрсдийн хөгжүүлж буй "Bard" нэртэй хиймэл оюуныг танилцуулж зөвхөн хайлтаас гадна Google Map, Gmail зэрэг бусад үйлчилгээнүүддээ интеграц хийхээ зарлав.

Google компанийн гүйцэтгэх захирал Сундар Пичай хэлэхдээ "Удахгүй та бүхэн нарийн төвөгтэй мэдээллийг хиймэл оюуны тусламжтайгаар хялбар ойлгож, вэбээс илүү их мэдээлэл авах боломжтой болохыг харах болно" хэмээсэн бөгөөд 9 настай хүүхдэд сансрын Жеймс Уэбб дурангийн тусламжтай нээсэн нээлтийг хялбаршуулж ойлгуулахад Bard-ийг ашиглаж болох тухай жишээ болгон дурдсан байна.


Ийнхүү хайлтын системүүдийн хооронд AI буюу хиймэл оюуны өрсөлдөөн ширүүсч ээлж дараалан AI-р хүч нэмсэн чатботуудыг танилцуулсаар байна.

БНХАУ ч мөн хиймэл оюуны энэхүү шилжилтээс хоцрохыг хүссэнгүй. "Baidu" компани ирэх гуравдугаар сард "ChatGPT"-тэй төстэй "Ernie Bot" үйлчилгээг гаргахаа зарласны дараа хувьцааны ханш нь мягмар гарагт 15 хувиар өссөн юм. Ингэснээр "Microsoft", "Google", "Baidu" гэсэн технологийн аваргууд хиймэл оюуны шинэ эрин үеийн эхлэлийг тавьж байна гэж дүгнэж болохоор байна.

Мэдээлэл технологийн хэсэг

That Might Motivate You № 11

THE BEST FEELING IS WHEN ALL YOUR TEAM IS WINNING



LIFE IS NOT AN ENDLESS RACE SOMETIMES YOU NEED TO STOP AND ENJOY THE LITTLE THINGS



THE EARLY BIRD CATCHES THE WORM





Компанийн аварга шалгаруулах 100 буудалт даамны тэмцээн 2 дугаар сарын 02-ны өдөр Дөл танхимд амжилттай зохион байгуулагдлаа. Энэ жилийн тэмцээн, уралдаанууд “ДЦС-4” ТӨХК байгуулагдсаны 40 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж байгаагаараа онцлог болж байна.



100 буудалт даамны аварга
Зуухан цехийн тамирчин, ОУХМ
Д.Эрдэмбилэг

100 буудалт даамны тэмцээнд нийт 37 тамирчин оюун ухаанаа сорьсноос:

- 1-р байранд Зуухан цехийн тамирчин, ОУХМ Д.Эрдэмбилэг
- 2-р байранд Зуухан цехийн тамирчин Э.Насанжаргал
- 3-р байранд Түлш дамжуулах цехийн тамирчин Э.Наранхүү нар шалгарлаа.

Шатарын тэмцээн 2-р сарын 3-ны өдөр зохион байгуулагдаж 39 тамирчин өрсөлдсөнөөс:



Шатарын аварга
Хими цехийн тамирчин З.Ганбат

- 1-р байранд Хими цехийн тамирчин З.Ганбат
- 2-р байранд Зуухан цехийн тамирчин, даамны ОУХМ Д.Эрдэмбилэг
- 3-р байранд Судалгаа хөгжлийн албаны тамирчин Б.Ганзориг нар шалгарлаа.

Тэмцээний нэгдсэн нээлт, хаалтын үйл ажиллагаа хавар спорт тоглоомын тэмцээний үеэр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.



Монголын волейболын залуучуудын хорлбооноос зохион байгуулсан U-21 насны аварга шалгаруулах волейболын тэмцээнд “Эрчим” /эрэгтэй/ баг тамирчид өрсөлдлөө. Нийт эрэгтэй 14 баг оролцсон уг тэмцээнээс манай баг мөнгөн медалийн болзол хангаж, С.Анх-Эрдэнэ “шилдэг хамгаалагч”, Ж.Батбилэг “шилдэг хаагч”-ийн шагнал хүртлээ.



“АЛТАН БӨМБӨГ-2022”

МХБХ-ноос оны шилдгүүдээ тодруулдаг “Алтан бөмбөг” ёслолын арга хэмжээ 2-р сарын 7-ны өдөр боллоо. 2022 оны шилдэг гадаад тоглогч”-оор “Хаан Хүнс-Эрчим” багийн Мишима Юута, эрэгтэй багийн “Шилдэг дасгалжуулагч”-аар 13 дахь удаагаа Супер цом болон Үндэсний дээд лигийн аварга болсон амжилтаараа “Эрчим” клубийн дасгалжуулагч Д.Батнасан нар шалгарч “Алтан бөмбөг” цомын эзэд боллоо.

Биеийн тамирын арга зүйч Б.Даринчулуун

ЯСНЫ СИЙРЭГЖИЛТИЙН ХЭМЖИЛТ

ЯСНЫ СИЙРЭГЖИЛТИЙН ХЭМЖИЛТ ХИЙЛГЭСЭН АЖИЛТНУУДЫН ҮР ДҮН




Х о о л шим тэжээлийн кабинет нь ясны с и й р э г ж и л т хэмжигч /Sonost 2000/ аппаратаар хэмжилт хийгээд 1 сар болж байна. Энэхүү хэмжилтийн үр

дүнг та бүхэндээ танилцуулъя.

Sonost 2000 аппаратаар компанийн нийт ажилтнуудын **16,7%** буюу 245 ажилтан хамрагдсан байна. Цех, нэгжээс 62 хүн буюу хамгийн олон хүн хамрагдсан нь Зуухан цех байлаа. Өөрсдийн эрүүл мэнддээ анхааран цаг зав гарган хамрагдаж байгаа цех, нэгжийнхээ ажилтнуудад талархал илэрхийлье.


Нийт хамрагдсан цех, нэгжийн хүний тоог доор графикаар харууллаа.

Хэмжилт хийлгэсэн хүний тоог цех, нэгжээр харуулбал



“**Sonost-2000**” яс сийрэгжилтийн аппаратаар ажиллагсдын ясны эрдэсжилтийн нягтыг тодорхойлоход ясны нягт хэвийн буюу ногоон түвшинд **127** ажилтан, зөөлрөлттэй буюу шар түвшинд **106** ажилтан насны ангилалаар нь авч үзвэл **20-40** насны ажилтнууд дийлэнх буюу **68%**-ийг, архаг сийрэгжилттэй буюу улаан түвшинд **12** ажилтан буюу насны ангиллаар нь авч үзвэл **44**-өөс дээш насныхан эзэлж байна.

Ясны нягтралын түвшинийг графикаар харуулбал



■ Хэвийн ■ Зөөлрөлттэй ■ Сийрэгжилттэй

Энэхүү үр дүнгээс харахад яс сийрэгжих, зөөлрөх өвчин улам залуужиж байгаа харагдаж байна. Цаашид бид амьдралын хэв маяг, дадал зуршлаа өөрчлөн, эрүүл зохистой хооллоход анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

Хэмжилтийн үр дүнд үндэслэн “**Ясны шөлөөр кальциа нөхье**” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.





УУШГИ ТООСЖИХ ӨВЧИН

Удаан хугацаанд үйлдвэрлэлийн тоос, тоосонцроор амьсгалсны улмаас уушгинд анхдагч архаг, нэвчмэл үрэвсэл улмаар уушгины хатуурал үүсгэдэг мэргэжлийн өвчнүүдийг уушги тоосжих өвчин гэнэ. Тоос тоосонцор ихтэй орчинд удаан байснаар амьсгалын замд орсон тоосонцрын хэсгүүд нь уушгинд завсрын холбогч эдийн үрэвсэл үүсгэж уушги хатуурна. Манай улсад 1973-2021 оны хооронд мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн 10119 тохиолдол бүртгэгдсэний 42 хувь буюу 4249 нь тоос тоосонцроос үүдэлтэй уушгины эмгэг, 2021 оны байдлаар мэргэжлээс шалтгаалсан эмгэгтэй 2810 иргэн хяналтанд байсны 52,6 % нь уушгины эмгэгтэй байна. Мэргэжлээс шалтгаалсан өвчин гэдэг бол хөдөлмөрлөх явцад ажлын байрны сөрөг хүчин зүйлсийн нөлөөгөөр үүсдэг эмгэг. Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагын хүрээнд сөрөг нөлөөллийг нь арилгах боломжгүй ажлын байрыг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл гэж үздэг.

Шалтгаан:

- Шууд тоос, тоосонцортой харьцдаг ажил эрхлэх - Тоос тоосонцор ихтэй уушгины эмгэгээр өвчлүүлэх эрсдэл өндөртэй ажлын байрт нүүрс, хүдэр, жоншны зэрэг бүх төрлийн уурхай ордог байна. Нүүрсний уурхайд нэвтрэгч, өрөмдөгч, бэхэлгээчин, тэсэлгээчин, маркшейдер, илчит тэрэгний машинч, бульдозерчин, экскаватор болон бусад хүнд машин механизмын оператор, ачигч нар мөн машин, төмөрлөг, нэхмэлийн үйлдвэрт ажиллагсад энэ эмгэгт илүү өртдөг байна.

Шинж тэмдэг:

- Шинж тэмдэг нь өвчний явцаас шалтгаалан харилцан адилгүй илэрнэ.
- Эхэн үед цээжээр өвдөх, амьсгаадах, ханиах /хуурай эсвэл салсархаг цэртэй ханиах/ шинж байнга бус ажиглагдана.
 - Өвчний эрт үед зөвхөн биеийн хүчний их ачааллын үед цаашдаа тайван байхад амьсгаадна.
 - Далны доогуур хатгаж өвдөх шинж илэрнэ.
 - Хуурай эсвэл бага зэргийн салсархаг цэртэй ханиалгадаг, зарим тохиолдолд нүүрсний тоосонцор агуулсан хар судалтай байна.
 - Гуурсан хоолойн архаг үрэвсэл, гуурсан хоолой тэлэх өвчин хавсарсан байвал их хэмжээгээр идээтэй цэр ялгарна.

Ангилал:

Тоосонцрын хэмжээ, шинж чанар, найрлага, эмнэл зүйн явц, рентген зурагт илрэх шинжүүдээр ангилна. Мэргэжлээс шалтгаалсан амьсгалын замын өвчлөл нь үйлдвэрлэлийн тоостой нөхцөлд тэр дундаа уул уурхайн салбарт ажилладаг хүмүүст элбэг тохиолддог. Ямар бүтээгдэхүүн олборлодог уурхайгаас шалтгаалж тоос тоосонцрын найрлага өөр өөр байдаг ба үүнээс шалтгаалж уушги тоосжих өвчин ч өөр өөр байна. Удаан хугацаанд нүүрсний тоосонцроор амьсгалсны улмаас уушгинд хатуурал үүсгэдэг өвчнийг антракоз, нүүрсний тоосны найрлаганд нь цахиурын чөлөөт давхар исэл агуулсан бол антрокосиликоз үүснэ. Алт жоншны уурхайд ажиллаж өрөмдөгч, нэвтрэгч, ялгагч зэрэг мэргэжлийн хүмүүст силикоз өвчин үүсэж байна. Эдгээр эмгэг илрэх хугацаа харилцан адилгүй боловч тухайн ажилтны мэргэжил, ажлын цаг,

хөдөлмөр хамгаалал, биеийн дархлаа, онцлог байдлаас шалтгаалан 10-аас дээш жил ажилласан иргэдэд үүсэж байна. Түүнчлэн манай орны хувьд агаарын бохирдол тулгамдсан асуудал болсон нь уушгины эмгэг даамжрахад нөлөөлж байна

Хүндрэл:

Уушги тоосжих өвчин нь уушги, гуурсан хоолойн хавдар, уушгины сүрьеэ, амьсгал зүрх судасны дутагдлаар хүндэрдэг ба энэ нь нас баралтын шалтгаан болж байна.



Урьдчилан сэргийлэлт:

- Тоос, тоосонцортой ажилладаг хүмүүс жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах (Уушги тоосжих өвчин нь эдгэрдэггүй тул өвчлөхөөсөө өмнө сэргийлэх нь маш чухал)
- Тоосонцортой ажилладаг ажилчдыг стандартын шаардлага хангасан хувийн хамгаалах хэрэгслэлээр хангах, хэрэглэж хэвшүүлэх
- Хөдөлмөр амралтын дэглэмийг зохицуулах, уураг амин дэмээр баялаг хоолоор хангах
- Биеийн тамирын ба амьсгалын дасгал хийж хэвшүүлэх
- Хорт зуршлаас сэргийлэх
- Шаардлагатай гэж үзвэл хөдөлмөрийн нөхцөлийг солих.

Оношлогоо:

Хэрэв танд уушгины өвчний зовиурууд илэрч байгаа бол мөн т нүүрс, шилэн хөвөн, цахиур зэрэгтэй ажиллаж байсан эсвэл ажилладаг бол дараах шинжилгээг хийлгэх хэрэгтэй.

- Уушгины эмчийн үзлэг
- Рентген
- Компьютер томографид уушгины дэлбэн, завсрын эдийн өвчин бий эсэхийг тодруулах
- Уушгины үйл ажиллагаа, цусан дах хүчилтөрөгчийн хэмжээг тогтоох
- Уушгины эдийн шинжилгээ

Эмчилгээ:

Уушги тоосжих өвчин нь эдгэрдэггүй бөгөөд нэгэнт өвчилсөн бол цаг алдалгүй эмчилгээ хийлгэж хяналтад авах шаардлагатай.

Ашигласан ном материал: Эрүүл мэндийн сайдын тушаал, Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн оношлогоо, эмчилгээний удирдамж

Эмнэлэгийн хэсэг